



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 81

Номгон

“Зорилтот өрхийн болон өрх толгойлсон
эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах”
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөр, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 60, 65 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, арга хэмжээг аймгийн жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж батлуулан, үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын
07-ны өдрийн 81 дүгээр тогтоолын хавсралт



**ЗОРИЛТОТ ӨРХИЙН БОЛОН ӨРХ ТОЛГОЙЛСОН
ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫГ
САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрт 2030 он гэхэд дэлхий нийтээрээ ядуурлаас ангижирсан байх зорилтыг дэвшүүлснээр улс орон бүр ядуурлыг бууруулах, өрх иргэдийнхээ аж байдлыг сайжруулах замаар улс орныхоо хөгжлийн түвшинг нэмэгдүүлэх зорилго, зорилт тавьж байна.

Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д “Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно”, “Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна”, “Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх”-аар тус тус зорилт дэвшүүлсэн.

Баянхонгор аймаг 2017 оны байдлаар 26270 өрхөд 87243 мянган хүн амтай хүйсээр ангилбал 43025 нь эрэгтэй, 44215 нь эмэгтэй амьдарч байгаа ба хүн амаар тооцсон ядуурлын түвшин 32.0%, ажилгүйдлийн түвшин 5.6 байна.

Нийт өрхийн 22,7 % буюу 5960 өрх зорилтот бага орлоготой өрх байгаагийн 6,8% буюу 1810 өрх доод хэрэглээтэй, 16,1% буюу 4240 өрх харьцангуй бага хэрэглээтэй эрсдэлд өртөхөд ойрхон өрх эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 5332 /21.4%/ өрх толгойлсон өрх байгаагийн 1275 /23.9%/ нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 4057 /76.1%/ нь эмэгтэй тэргүүлэгчтэй, үүний 2154 /53.1%/ эмэгтэй тэргүүлэгчид 18 хүртэлх хүүхэдтэй, 2647 өрх толгойлсон эх 3 хүртэлх ам бүлтэй, 1220 нь 3-5 ам бүлтэй, 190 нь 3 ба түүнээс дээш ам бүлтэй байна.

Хөдөлмөрийн чадвартай 20-50 насны гишүүнтэй өрхийн 10.6 хувийг өрх толгойлсон эмэгтэй, 8.2 хувийг өрх толгойлсон эцэг, 6.5 хувь нь албан ёсоор гэр бүлээ цуцлуулсан байна.

Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Өрх толгойлсон болон бага орлоготой өрхийн гишүүдэд үзүүлэх дэмжлэг, боловсрол,

эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална”, “Өрх толгойлсон эх /эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 60 дахь арга хэмжээ “Өрх толгойлсон эцэг эхэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ”, 65-д “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ” заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

2.1 Энэхүү хөтөлбөрийн зорилго нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлж, тэдгээр өрх, өрхийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, санаачлага, боломжид тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн үйлчилгээг багцлан хүргэх замаар зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг эхийн хөгжил, хамгааллыг сайжруулан амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэхэд оршино.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 3.1. Өрхийн хэрэгцээ, гишүүдийн оролцоо, санаачлага, чадвар, боломжийг харгалзах
- 3.2. Орон нутаг, олон нийт, бүх салбарын оролцоонд тулгуурлах
- 3.3. Хөтөлбөрт өрх, түүний гишүүд сайн дурын үндсэн дээр хамрагдах
- 3.4. Ил тод байх
- 3.5. Өрхөд хүргэх нийгмийн үйлчилгээ нь иж бүрэн багцлагдсан байх

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГОД ХҮРЭХИЙН ТУЛД ДАРААХ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Зорилт 1. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдсан 3-8 түвшний өрхийг сонгон, өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж, чадавхид тулгуурлан өрхийг хөгжүүлэх, амьжиргааг сайжруулах тусгайлсан арга зүйг ашиглан сумын Нийгмийн түншлэлийн баг, өрхийн гишүүдтэй хамтран өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хөгжүүлэх

Үр дүн: Сонгогдсон өрхийн нөхцөл байдлын үнэлгээ хийлгэж, хөгжлийн бүлгээ тодорхойлон, өрх бүрт өрхийн хөгжлийн дэвтрийг ашиглан, хөгжлийн төлөвлөгөө хийсэн байна.

1.1. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдсан 3-8 түвшний өрхийг сонгох

1.2. Сонгосон өрхийн тоогоор өрхийн хөгжлийн дэвтрийг хэвлүүлэх

1.3. Тусгайлсан арга зүйг ашиглан сумын Хүн амын хөгжлийн асуудлаар салбар зөвлөл сонгогдсон өрхүүдийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж, чадавхийг судлах үнэлгээний сургалтуудыг зохион байгуулж, үнэлгээний дүнг нэгтгэх, эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх

1.4. Өрхийн нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, холбогдох үйлчилгээ, арга хэмжээг төлөвлөх, санал боловсруулах

1.5. Сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөлийн гишүүдэд сонгогдсон өрхүүдийг хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан ажилласан цагийн хөлсийг тооцож олгох журам гарган мөрдөх

1.6. Сумын Засаг даргын зөвлөлөөр өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан өрхүүдийн жагсаалтыг баталгаажуулан, өрхтэй ажиллах сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөлийн гишүүдийн зардал, урамшуулал, өрхийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх

Зорилт 2. Сонгож авсан зорилтот өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх замаар амьжиргааны түвшинг дээшлүүлэх

Үр дүн Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа иргэнийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зуучилж, мэргэжил ур чадварыг ахиулах болон мэргэжил эзэмшиж, гишүүдийн 50-иас доошгүй хувь нь байнгын ажлын байртай болсон байна.

Зорилт 2-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа.

2.1. Зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, зөвлөгөө мэдээллээр хангах сургалтын арга хэмжээнд хамруулах

2.2. Үйлдвэрлэл дээрх болон мэргэжлийн давтан сургалтуудад хамруулж, байнгын, түр ажлын байранд зуучлах

2.3. Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах

2.4. Бизнесийн санаагаа хөгжүүлэх 1-2 сарын сургалтад хамруулан, санааг төсөл болгон, нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангаас тоног төхөөрөмж, санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлүүлэх

2.5. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ногоо тарих газрын асуудлыг судалж, шийдвэрлүүлэх

2.6. Зорилтот өрхийг туслах малчин, дагалдах малчнаар олон малтай болон сайн малчидтай гэрээ байгуулан малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

2.7.Зорилтод өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөрийн зорилт 1-ын 1.1.1-1.1.4 дэх арга хэмжээнд хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Зорилт 3. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг зорилтот өрхийн гишүүн бүрт оновчтой хүргэх

Үр дүн: Зорилтот өрх бүрт нийгмийн үйлчилгээг цогцоор хүргэж, сонгогдсон өрхийн 30%-д хөгжлийн ахиц гарсан байна.

Зорилт 3-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа;

3.1. Зорилтот өрх, өрхийн гишүүдийг хууль тогтоомжид заасан нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах

3.2. Нийгмийн даатгалын тухай хуулийг иргэдэд сурталчлан таниулж, сайн дурын даатгалд хамрагдах боломжоор хангах

3.3. Зорилтот өрхийн гишүүдийг чадавхижуулах, эерэг дадал, хэвшил төлөвшүүлэх, өрхийн гишүүдийн нийгэм, гэр бүл, хөршийн харилцаагаа сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах

3.4. Зорилтот өрхийн эх, хүүхдийн эрүүл мэнд, ариун цэврийн байгууламж зэрэг асуудлаар тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх

3.5. Зорилтот өрхийн суурь боловсрол эзэмших насны хүүхдийг сургуульд хамрагдах, суралцах боломжийг бүрдүүлж, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцас зэргийн үнийг хөнгөлөх, чөлөөлөх, дотуур байраар хангах

3.6. Зорилтот өрхийн сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах

3.7. Зорилтот өрхийн сургууль завсардсан хүүхдийг албан бус сургалтад хамруулж, дүйцүүлэх хөтөлбөрөөр зохих шатны боловсрол эзэмшүүлэх, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцасны үнийг хөнгөлөх, чөлөөлөх

3.8.Зорилтот өрхийн үл хөдлөх хөрөнгө, ялангуяа газрын асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн ажилтанууд холбон зуучилж, салбар байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх

3.9.Зорилтот өрхийн насанд хүрсэн иргэдийг насан туршийн боловсролын байгууллагатай хамтран бичиг үсгийн сургалтанд хамруулах

3.10. Сум бүр Залуучуудын хөгжлийн төвийн амьдрах ухааны 12 модульд 1-2 хүнийг суулгаж, сургагч багшаар бэлтгэн, зорилтот өрхийн залуучуудыг амьдрах ухааны 12 модуль сургалтад хамруулж, зан үйлийг өөрчлөх

3.11. Зорилтот өрхийн ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хүүхдийг хүүхдийн өөрөө удирдлагын байгууллага, дугуйланд хамруулж, авъяас чадварыг нээн хөгжүүлэх, тэмцээн, уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх, тухайн хүүхэдтэй ажилласан багш нарт жилийн эцэст хүүхдийн хөгжлийн ахицад үндэслэн урамшуулал олгодог болох

3.12. Зорилтот өрхийн их, дээд сургууль, коллежид суралцах эрх авсан хүүхэд, өрхийн гишүүнийг сургалтын тэтгэлэг, буцалтгүй тусламж, зээлд хамруулах, дэмжлэг үзүүлэх

Зорилт 4. Өрхийн гишүүдийн сөрөг зан үйл, дадал хэвшлийг өөрчилж, гэр бүлийн эерэг, таатай харилцааг төлөвшүүлэх

Үр дүн: Гэр бүлийн таатай орчин бүрдсэн өрхийн тоо жил бүр нэмэгдсэн байна.

Зорилт 4-ын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа;

4.1. Охид, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөлөөлөл, соён гэгээрүүлэх ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

4.2. Амьдралын итгэл үнэмшил олгох сургалтыг иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

4.3. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн эрх зүйн боловсрол олгох сургалтыг төрийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэх

4.4. Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх арга зүйн сургалт, төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэх

4.5 Сөрөг зан үйлийг өөрчлөх төрөл бүрийн арга хэмжээнд өрхийн гишүүдийг оролцуулан бусдад үлгэрлэх зан үйлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах

4.6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өрхүүдийн ахиц өөрчлөлтийг баталгаажуулсан нэвтрүүлгийг бэлтгэн явуулах

4.7. Зан үйлээ өөрчлөхөд нь нөлөөлөх нийгэм хамт олонд түшиглэсэн нөлөөллийн ажлыг үе шатлалтайгаар хэрэгжүүлэх

Зорилт 5. Өрх толгойлсон эцэг, эхийн эрүүл аюулгүй амьдрах, хөдөлмөр эрхлэх таатай орчинг бүрдүүлэн, үр хүүхдээ зөв зан үйлтэй, хүмүүжилтэй өсгөх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, амьжиргааг дэмжиж, чадваржуулж, амьдралын чанарыг сайжруулах

Үр дүн: Жил бүр өрх толгойлсон эцэг, эхчүүдийн 15-20 хувьд үр хүүхдээ өсгөх, амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

Зорилт 5-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

5.1. Бүх шатны Засаг дарга, сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөлтэй хамтран өрх толгойлсон эцэг, эхчүүдийн бүртгэл мэдээллийн сантай болж, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, тухайн өрхөд шаардлагатай дэмжлэг туслалцааг тодорхойлон, төлөвлөгөө гарган, ажиллах

5.2. Өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Өрх толгойлсон эцэг эхчүүдийг дэмжих сан” байгуулан, хүүгүй санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах

5.3. Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн 1.3 дахь “Өрх толгойлсон, олон хүүхэдтэй эхчүүдэд хүүхдээ эрүүл өсгөх “Миний хүүхэд” төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэхэд “Өрх толгойлсон эцэг эхчүүдийг дэмжих” сангаас дэмжлэг үзүүлэх

5.4. Өрх толгойлсон эцэг, эхчүүд хөдөлмөрийн насны хүүхдүүдтэйгээ хамтран хөдөлмөр эрхлэхэд сангуудаас бага хүүтэй, хүүгүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх

5.5. Бичил бизнес эрхлэгч өрх толгойлсон эцэг, эхчүүдийн үйлдвэрлэлийг өргөтгөхөд тоног төхөөрөмж, байр, зээлийн бодлогоор дэмжиж, шат дамжлагатай томоохон үйлдвэрлэгч болгох /гутал, оёдол, хүнсний г.м/

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

6.1. Сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан орон нутагт хэрэгжүүлж ажиллана.

6.2. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлсон мэдээллийн сангаас хөтөлбөрт сонгогдох өрхийн жагсаалтыг сумын Засаг даргад хүргүүлж, энэхүү хөтөлбөрийн зарчмын дагуу өрхийн гишүүдтэй сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөлийн гишүүдийг оролцуулан уулзалт, ярилцлага зохион байгуулж, өрхийг өөрсдийн санал хүсэлтийн дагуу сонгох ба сум бүр жилд 15 өрхийг сонгон ажиллах, энэ өрх дотор 10% өрх толгойлсон эцэг, эхчүүдтэй өрх байна. Баянхонгор сумын хувьд баг бүрт 15-20 өрхийг сонгоно.

6.3. Сумын хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл өрхийн гишүүдтэй хамтран өрхүүдтэй ажиллах ажлын хуваарийг гарган, сумын Засаг даргаар баталгаажуулан, ил тод нээлттэй самбарт байрлуулж, хуваарийн дагуу ажиллана.

6.4. Сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл сонгогдсон өрхүүдийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж, чадавхийг судлах үнэлгээний сургалтуудыг зохион байгуулж, үнэлгээний дүнг нэгтгэж, зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээнд өрхийн хөгжлийн гурвалжинг ашиглан 3 түвшин, 7 бүлэг, 14 асуудлын 38 үзүүлэлтийг багтаан өрхийн хөгжлийн бүлгийг тодорхойлно. Үүнд:

Хөгжлийн түвшин	Үнэлэх оноо
Заавал хөгжих өрх	60, түүнээс дээш оноотой
Хөгжлийн төлөөх өрх	61-80 оноотой
Хөгжлийг дэмжигч өрх	81-90 оноотой
Хөгжлийг бүтээгч өрх	91-ээс дээш оноотой

6.5. Хөгжлийн түвшингээр ангилсан өрхүүдэд тусгайлсан хөтөлбөрийг сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл гарган, салбар дундын хамтын ажиллагаатайгаар хөгжүүлэх, хөгжлийн түвшинг ахиулах ажлыг хэрэгжүүлнэ. Тухайлбал, заавал хөгжих өрхийг хөгжүүлж, хөгжлийг бүтээгч өрх болгох төлөвлөгөө гаргах гэх мэт.

6.6. Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд жил бүр тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгаж, аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган, хэрэгжилтэд Нийгмийн бодлогын хэлтэс хяналт тавьж ажиллана.

6.7. Зорилтот өрхийн хөгжлийг сайжруулахаар сонгогдсон өрхүүдээс байгууллага бүр өрхийн гишүүдээс нэг хүнийг сонгон, ажлын байраар хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалтууд хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, хөгжлийн түвшинг ахиулсан байна.

6.8. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байраар хангах, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, төсөл, хөтөлбөрт хамруулах, аливаа тусламж үйлчилгээ, арга хэмжээнд өрх, иргэд, хүүхдийг хамруулахаар бол энэ хөтөлбөрт сонгогдсон өрхүүдийг хамруулах бодлого баримтална.

6.9. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар удирдлага, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллана.

6.10. Зорилтот өрхтэй ажиллах сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон сонгогдсон өрхийг дараагийн хөгжлийн түвшинд очих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн тооцоог сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл гаргаж, ИТХ-аараа батлуулж, хэрэгжүүлнэ. Мөн орон нутгийн хөгжлийн сангаас өрхүүдийг ажлын байраар хангах, тус сангийн хөрөнгөөр орон нутагт хийгдэх зарим ажлуудыг бүлэг, нөхөрлөл болгон хийлгэх арга хэмжээ авна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамруулан орлоготой болгох ажлыг хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2018	2019	2020

1	Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа хүний байнгын ажлын байртай болсон	хувь	30	40	50
2	Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа хүн ам хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд бүрэн хамрагдаж, мэргэжил, ур чадвараа ахиулсан, эсхүл мэргэжил эзэмшсэн байдал	хувь	50	80	100
3	Өрхийн гишүүд нийгмийн даатгалд бүрэн хамрагдалт	хувь	30	50	80
4	Өрхийн гишүүд иргэний бичиг баримтын зөрчлөө арилгасан байдал	хувь	70	90	100
5	Нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, болзлыг хангасан иргэд шаардлагатай үйлчилгээнд хамрагдалт	хувь	30	50	70
6	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшин	хувь	100	100	100
7	Сургууль завсардсан хүүхдүүд боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдалт	хувь	70	90	100
8	Суурь боловсрол эзэмших насны хүүхдүүд сургуульд хамрагдалт	хувь	90	90	100
9	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын түвшин	хувь	100	100	100
10	Өрхийн 5 хүртэлх насны хүүхдүүд өсөлт, хөгжлийн хяналт, вакцинжуулалтад хамрагдалт	хувь	100	100	100
11	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хяналт, үйлчилгээнд хамрагдалт	хувь	100	100	100

НАЙМ. ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭЛБЭР, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

8.1. Хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд дэх үйл ажиллагааг сум бүр жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

8.2. Хэрэгжүүлэх хугацаа: 2018-2020 онд хэрэгжүүлнэ

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж, дүнг мэдээлж ажиллана. Төлөвлөгөөний хэрэгжилтээ сум өөрөө үнэлсэн байна. Сумын Засаг дарга, сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл зорилтот өрхийн хөгжлийн ахиц, хэрэгжүүлсэн ажил үйлчилгээний үр дүнгийн талаарх тайлан, мэдээллийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд жил бүр тайлагнаж үнэлүүлнэ.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалт, аймаг, сумын нийгэм эдийн засаг, бусад төсөл хөтөлбөр, төсвийн санхүүжилттэй нягт уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар

хангах, хяналт тавих үүргийг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцан, Гэр бүл хүүхэд залуучуудын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол соёл урлагын газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын алба, сумдын Засаг даргын тамгын газар, сумдын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөлүүд, хөтөлбөр, төслийн газруудын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлнэ.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 10.1. Улс, орон нутгийн төсөв
- 10.2. Засаг даргын нөөц хөрөнгө
- 10.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
- 10.4. Нийгмийн халамжийн сан болон ОНОТХ-ийн сангийн хөрөнгө
- 10.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;
- 10.6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгө
- 10.7. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив
- 10.8. Олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл
- 10.9. Иргэд, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулагчид
- 10.10. бусад эх үүсвэр

АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

11.1. Сумын Хүн амын хөгжлийн асуудлаарх салбар зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлнэ.

11.2. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар сумдын тайланг нэгтгэн, хөтөлбөрийн хэрэгжилтийг заалт бүрээр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хөтөлбөрийн хэрэгжилт гаргадаг маягтыг дагуу гаргаж, үнэлэн аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргад танилцуулан, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

11.3. Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд тулгуурлан Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах хөтөлбөрийн биелэлтийг гаргаж, жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний үндэсний газарт хүргүүлнэ.

11.4. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн шалгуур үзүүлэлт, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны

удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгө хүндээ хэрхэн хүрч зохих дэмжлэг болж чадсаныг судалгаа, шинжилгээ, олон нийтийн оролцооны аргаар тогтоох, цаг үеийн байдалтай холбогдуулан хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, зөвлөмж, санал дүгнэлт гаргана.

_____ооо_____